



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 401

Улаанбаатар хот

Гэрээний үүргийн хэрэгжилт хангах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан 2020/17/к дугаар бүхий “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”, 2019/17/к контрактын нэмэлт гэрээний 2, 3 дугаар заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын хөдөлмөрийн харилцаа дуусгавар болж байгаатай холбогдуулан Б.Мөнхбаттай байгуулсан 2020/17/к дугаар бүхий “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-ний салшгүй хэсэг болох 2019/17/к контрактын нэмэлтийн 2, 3-т заасны дагуу холбогдох тооцоог хийж, гэрээний хэрэгжилтийг хангахыг үйлдвэрийн газрын Захирал Д.Тогтохсүрэнд зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Н.ГАНБОЛД